

ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын ерөнхий боловсролын сургуулийн  
2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХӨА-2024/195/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Мөрөн сум 2024 он</p>	<p>Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар Утас: 88883317 Цахим хаяг: <a href="mailto:erdenebaatara@audit.gov.mn">erdenebaatara@audit.gov.mn</a> Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр Утас: 99089114 Цахим хаяг: <a href="mailto:tegshdelgerb@audit.gov.mn">tegshdelgerb@audit.gov.mn</a> Аудитор: Г.Ичинхорлоо Утас:88688168 Цахим хаяг: <a href="mailto:ichinkhorloog@audit.gov.mn">ichinkhorloog@audit.gov.mn</a> Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа Утас:99389208 Цахим хаяг: <a href="mailto:b_myadagmaa@yahoo.com">b_myadagmaa@yahoo.com</a> Аудитор Д.Оюундаваа Утас: 99389692 Цахим хаяг: <a href="mailto:Oyundavaa9692@gmail.com">Oyundavaa9692@gmail.com</a></p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2024.02.26 № 01/163  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЧАНДМАНЬ-ӨНДӨР СУМЫН  
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
А.ОТГОНБАЯР ТАНАА

### Хараат бус аудиторын дүгнэлт

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Чандмань-өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Чандмань-өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх мөнгөн хөрөнгийн дүн өмнөх оноос 76,038.0 мянган төгрөгөөр өссөн байна.

#### Аудитын гол асуудал

Багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих хөтөлбөр арга хэмжээний зардал болон цахим хэрэглээний батлагдсан зардлаас 5,102.0 мянган төгрөгийг зориулалт арга хэмжээний дагуу зарцуулаагүй зөрчилд 2,500.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 2,602.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

#### Бусад асуудлын хэсэг

Чандмань өндөр сумын Ерөнхий боловсролын сургууль нь тайлант онд 6 зорилт 30 арга хэмжээ төлөвлөн хэрэгжилт 80.0 хувьтай биелүүлж ажилласан байна.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

6724040229

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *А.Эрдэнэбаатар* А.ЭРДЭНЭБААТАР



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>365,606,790.82</b>	<b>438,188,131.59</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>46,613,336.46</b>	<b>122,651,360.23</b>
<b>31200</b>	<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	<b>46,613,336.46</b>	<b>122,651,360.23</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>46,613,336.46</b>	<b>122,651,360.23</b>
31211	Төрийн сангийн харилцах	46,613,336.46	122,651,360.23
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>9,215,408.00</b>	<b>7,686,940.00</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,190,008.00	0
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>8,025,400.00</b>	<b>7,686,940.00</b>
33510	Байгууллагаас авах авлага	8,025,400.00	7,686,940.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>309,778,046.36</b>	<b>307,849,831.36</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>53,214,456.42</b>	<b>66,929,032.42</b>
35110	Тусгай зориулалттай материал	51,667,456.42	65,669,832.42
35130	Эм боох материал	1,547,000.00	1,259,200.00
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>251,868,589.94</b>	<b>236,835,798.94</b>
35410	Бичиг хэргийн материал	1,892,000.00	1,637,000.00
35420	Аж ахуйн материал	1,083,206.00	939,640.00
35440	Түлш, шатах тослох материал	35,859,375.00	36,457,750.00
35450	Барилгын засварын материал	9,421,300.00	4,871,500.00
35460	Хүнсний материал	32,560,400.00	21,877,600.00
35470	Бусад хангамжийн материал	171,052,308.94	171,052,308.94
35600	Мал амьтад	4,695,000.00	4,085,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,786,113,197.40</b>	<b>1,734,728,237.00</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,786,113,197.40</b>	<b>1,734,728,237.00</b>
39100	Газар	0	0
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,716,801,197.40</b>	<b>1,665,416,237.00</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,654,264,818.00	1,654,264,818.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-214,494,332.44	-259,827,210.52
39203	Авто-тээврийн хэрэгсэл	65,762,960.00	65,762,960.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-12,553,703.25	-20,774,073.21
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	209,217,757.48	245,143,757.48
39206	Хуримтлагдсан элэгдэл	-71,387,218.23	-105,927,252.99
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	52,740,819.10	57,339,706.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	-27,724,760.98	-31,998,570.94
39214	Бусад үндсэн хөрөнгө	35,352,000.00	35,352,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-12,431,200.28	-14,651,400.32
39217	Ном	38,054,058.00	40,731,502.90
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>69,312,000.00</b>	<b>69,312,000.00</b>
39301	Программ хангамж	6,687,000.00	6,687,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,087,000.00	-1,087,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	63,712,000.00	63,712,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,151,719,988.22</b>	<b>2,172,916,368.59</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>3,049,900.00</b>	<b>8,157,824.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>3,049,900.00</b>	<b>8,157,824.00</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>3,049,900.00</b>	<b>8,157,824.00</b>
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	3,049,900.00	0
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>0</b>	<b>8,157,824.00</b>

41361	Байгууллагад төлөх өглөг	0	8,157,824.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,148,670,088.22</b>	<b>2,164,758,544.59</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>2,148,670,088.22</b>	<b>2,164,758,544.59</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	660,225,258.00	660,225,258.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	660,225,258.00	660,225,258.00
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,432,103,375.26</b>	<b>1,448,191,831.63</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	1,432,103,375.26	1,432,103,375.26
51220	Тайлант үеийн үр дүн		16,088,456.37
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	56,341,454.96	56,341,454.96
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,151,719,988.22</b>	<b>2,172,916,368.59</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,564,933,222.50</b>	<b>1,878,470,908.40</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>38,476,622.50</b>	<b>23,569,308.40</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	38,476,622.50	22,957,108.40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	38,476,622.50	22,957,108.40
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,855,400.00	2,749,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,975,000.00	350,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	32,646,222.50	19,857,708.40
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	00.00	612,200.00
122001	Хандив тусламж /дотоод/	00.00	612,200.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,526,456,600.00</b>	<b>1,854,901,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,371,456,600.00	1,742,521,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,371,456,600.00	1,742,521,600.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	155,000,000.00	112,380,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	155,000,000.00	112,380,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,526,547,522.90</b>	<b>1,862,382,452.03</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,526,547,522.90</b>	<b>1,862,382,452.03</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,463,438,333.38	1,804,154,736.39
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,007,362,170.00	1,254,021,489.74
210101	Үндсэн цалин	1,007,362,170.00	863,789,536.09
210102	Нэмэгдэл	00.00	338,216,120.65
210104	Урамшуулал	00.00	52,015,833.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	125,911,156.02	157,966,922.49
210201	Тэтгэврийн даатгал	94,015,352.02	108,177,348.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,996,209.00	12,617,883.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,396,967.00	10,026,419.85
210204	Ажилгүйдлийн даатгал	1,591,146.00	2,466,984.07
210205	Эрүүл мэндийн даатгал	15,911,482.00	24,678,286.79
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	64,299,456.00	99,781,209.36
210301	Гэрэл, цахилгаан	18,313,331.00	29,925,184.36
210302	Түлш, халаалт	45,986,125.00	69,640,625.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	215,400.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	15,601,140.00	20,619,902.00
210401	Бичиг хэрэг	895,500.00	1,788,900.00
210402	Тээвэр, шатахуун	7,103,900.00	9,882,040.00

Хөвсгөл аймгийн Чандмань-өндөр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,436,740.00	8,068,962.00
210408	Бараа материал акталсны зардал	1,165,000.00	880,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>116,848,650.00</b>	<b>121,791,520.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,365,210.00	734,120.00
210502	Хоол, хүнс	114,483,440.00	121,057,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>10,508,050.00</b>	<b>16,085,200.00</b>
210604	Урсгал засвар	10,508,050.00	16,085,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>9,889,200.00</b>	<b>12,854,500.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	55,000.00	3,817,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,114,200.00	9,037,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>113,018,511.36</b>	<b>121,033,992.80</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,657,150.00	12,434,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,642,940.00	14,012,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	82,718,421.36	94,587,292.80
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>63,109,189.52</b>	<b>58,227,715.64</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>62,614,000.00</b>	<b>57,762,700.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	62,094,000.00	57,067,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	520,000.00	695,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>495,189.52</b>	<b>465,015.64</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	495,189.52	465,015.64
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>38,385,699.60</u></b>	<b><u>16,088,456.37</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>38,385,699.60</u></b>	<b><u>16,088,456.37</u></b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,531,831,600.00</b>	<b>1,859,068,600.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>5,375,000.00</b>	<b>4,167,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>5,375,000.00</b>	<b>4,167,000.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>5,375,000.00</b>	<b>1,167,000.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,400,000.00	3,817,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,975,000.00	350,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,526,456,600.00</b>	<b>1,854,901,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,371,456,600.00</b>	<b>1,742,521,600.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,371,456,600.00	1,742,521,600.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>155,000,000.00</b>	<b>112,380,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	155,000,000.00	112,380,000.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,442,265,263.54</b>	<b>1,747,104,576.23</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,442,265,263.54</b>	<b>1,747,104,576.23</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,382,725,974.02</b>	<b>1,683,829,960.59</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,007,362,170.00</b>	<b>1,246,630,665.74</b>
210101	Үндсэн цалин	727,034,082.00	856,398,712.09
210102	Нэмэгдэл	226,692,575.00	338,216,120.65
210104	Урамшуулал	53,635,513.00	52,015,833.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>125,742,738.02</b>	<b>156,893,854.49</b>

210201	Тэтгэврийн даатгал	85,589,945.78	107,104,285.35
210202	Тэтгэмжийн даатгал	10,057,539.78	12,617,878.43
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,046,033.44	10,026,419.85
210204	Ажилгүйдлийн даатгал	2,004,470.15	2,466,984.07
210205	Эрүүл мэндийн даатгал	20,044,748.87	24,678,286.79
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>70,870,831.00</b>	<b>100,379,584.36</b>
210301	Гэрэл, цахилгаан	18,097,931.00	29,925,184.36
210302	Түлш, халаалт	52,557,500.00	70,239,000.00
210303	Цэвэр, бохир ус	215,400.00	215,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>115,817,555.00</b>	<b>107,682,600.00</b>
210502	Хоол, хүнс	115,817,555.00	107,682,600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>7,479,850.00</b>	<b>11,535,400.00</b>
210604	Урсгал засвар	7,479,850.00	11,535,400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>11,514,200.00</b>	<b>12,087,500.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,400,000.00	3,050,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,114,200.00	9,037,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>43,938,630.00</b>	<b>48,620,356.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,268,190.00	34,692,656.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,670,440.00	13,927,700.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>59,539,289.52</b>	<b>63,274,615.64</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>59,044,100.00</b>	<b>62,809,600.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	59,044,100.00	62,809,600.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>495,189.52</b>	<b>465,015.64</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	495,189.52	465,015.64
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>89,566,336.46</b>	<b>111,964,023.77</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>42,953,000.00</b>	<b>35,926,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>42,953,000.00</b>	<b>35,926,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>42,953,000.00</b>	<b>35,926,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	42,953,000.00	35,926,000.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-42,953,000.00</b>	<b>-35,926,000.00</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>46,613,336.46</b>	<b>76,038,023.77</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	46,613,336.46
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	46,613,336.46	122,651,360.23

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	660,225,258.00	56,341,454.96	1,432,103,375.26	2,148,670,088.22

<b>2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>660,225,258.00</b>	<b>56,341,454.96</b>	<b>1,432,103,375.26</b>	<b>2,148,670,088.22</b>
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>660,225,258.00</b>	<b>56,341,454.96</b>	<b>1,432,103,375.26</b>	<b>2,148,670,088.22</b>
Тайлант үеийн үр дүн	0	0	16,088,456.37	16,088,456.37
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>660,225,258.00</b>	<b>56,341,454.96</b>	<b>1,448,191,831.63</b>	<b>2,164,758,544.59</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,792,537,900.00</b>	<b>1,670,650,576.23</b>	<b>121,887,323.77</b>	93
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,792,537,900.00</b>	<b>1,670,650,576.23</b>	<b>121,887,323.77</b>	93
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,718,766,200.00</b>	<b>1,607,840,976.23</b>	<b>110,925,223.77</b>	94
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,345,892,200.00</b>	<b>1,246,630,665.74</b>	<b>99,261,534.26</b>	93
210101	Үндсэн цалин	925,731,400.00	856,398,712.09	69,332,687.91	93
210102	Нэмэгдэл	366,473,000.00	338,216,120.65	28,256,879.35	92
210104	Урамшуулал	53,687,800.00	52,015,833.00	1,671,967.00	97
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>168,236,800.00</b>	<b>156,893,854.49</b>	<b>11,342,945.51</b>	93
210201	Тэтгэврийн даатгал	114,401,100.00	107,104,285.35	7,296,814.65	94
210202	Тэтгэмжийн даатгал	13,459,000.00	12,617,878.43	841,121.57	94
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,767,100.00	10,026,419.85	740,680.15	93
210204	Ажилгүйдлийн даатгал	2,691,800.00	2,466,984.07	224,815.93	92
210205	Эрүүл мэндийн даатгал	26,917,800.00	24,678,286.79	2,239,513.21	92
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>107,723,500.00</b>	<b>107,682,600.00</b>	<b>40,900.00</b>	100
210502	Хоол, хүнс	107,723,500.00	107,682,600.00	40,900.00	100
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>12,347,300.00</b>	<b>12,087,500.00</b>	<b>259,800.00</b>	98
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,062,200.00	3,050,000.00	12,200.00	100
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,285,100.00	9,037,500.00	247,600.00	97
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>84,566,400.00</b>	<b>84,546,356.00</b>	<b>20,044.00</b>	100
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	70,638,700.00	70,618,656.00	20,044.00	100
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,927,700.00	13,927,700.00	0.00	100

213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>73,771,700.00</b>	<b>62,809,600.00</b>	<b>10,962,100.00</b>	85
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>73,771,700.00</b>	<b>62,809,600.00</b>	<b>10,962,100.00</b>	85
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	73,771,700.00	62,809,600.00	10,962,100.00	85
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,792,537,900.00</b>	<b>1,746,688,600.00</b>	<b>45,849,300.00</b>	97
31	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,742,521,600.00</b>	<b>1,742,521,600.00</b>	<b>0.00</b>	100
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,742,521,600.00	1,742,521,600.00	<b>0.00</b>	100
35	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>3,412,200.00</b>	<b>4,167,000.00</b>	<b>--754,800</b>	124
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,062,200.00	3,817,000.00	-754,800	105
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	350,000.00	350,000.00	0.00	100
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	46,604,100.00	0	46,604,100.00	0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	46,613,336.46	<b>-46,613,336.46</b>	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	122,651,360.23	<b>122,651,360.23</b>	-

## 2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

данс	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	0	-
2	<b>I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>112,380,000.00</b>	<b>111,914,984.36</b>	<b>465,015.64</b>	<b>100</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>112,380,000.00</b>	<b>111,914,984.36</b>	<b>465,015.64</b>	<b>100</b>
210	Бараа, үйлчилгээний зардал	112,380,000.00	111,914,984.36	465,015.64	100
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	100,380,000.00	100,379,584.36	415.64	100
210301	Гэрэл цахилгаан	28,380,000.00	29,925,184.36	1,545,184.36	105
210302	Түлш, халаалт	70,000,000.00	70,239,000.00	-239,000.00	100
210303	Цэвэр, бохир ус	2,000,000.00	215,400.00	1,784,600.00	11
2106	Эд хогшил худалдан авах	12,000,000.00	11,535,400.00	464,600.00	96
210604	Урсгал засвар	12,000,000.00	11,535,400.00	464,600.00	96
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>112,380,000.00</b>	<b>111,914,984.36</b>	<b>465,015.64</b>	<b>100</b>
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>112,380,000.00</b>	<b>111,914,984.36</b>	<b>465,015.64</b>	<b>100</b>
132001	Орон нутгийн төсвөөс	112,380,000.00	111,914,984.36	465,015.64	100
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-

5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
---	---	---	---	---	---

### 3.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5,102.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 2,500.0 мянган төгрөгийн зөрчилд 1 акт, 2,602.0 мянган төгрөгийн зөрчилд дахин давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой залруулгын алдаа илрээгүй болно.

Нийт илрүүлсэн 5,102.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 19,322.7 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

#### 5.1Акт

Багшийн хөгжлийг дэмжих чиглэлээр батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргахдаа мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, багш, ажилтны мэргэжлийн хөгжлийг хангах, зөвлөн туслах чиг үүрэгтэй, аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын арга зүйн хэлтсийн дарга Я.Дүүрэнбилэгтэй гэрээ байгуулан, сургалт хийлгэж төсвөөс 2,500.0 төгрөгийн төлбөр төлсөн байгаа нь Боловсролын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.5-д “Аймаг, нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтэс харьяа нутаг дэвсгэртээ дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: өмчийн хэлбэр үл харгалзан бүх түвшний боловсролын сургалтын байгууллагад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, багш, ажилтны мэргэжлийн хөгжлийг хангах, зөвлөн туслах, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;” заалт, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байгаад акт бичигдлээ.

#### 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

Тус сургуулийн үндсэн хөрөнгөнд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 71 нэр төрлийн 60,779.2 мянган төгрөгийн 175 хөрөнгө бүртгэлтэй байгаа нь УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн параграф 67, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;” заалт болон ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар бүлгийн 7.1 заалттай тус тус нийцээгүй, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг ОНӨГ-т хүргүүлэн шийдвэрлүүлж, үр дүнг нягтлан бодох бүртгэлд тусгах

2. Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

Танхимаас гадуур сургалтын\_хөтөлбөр арга хэмжээний зардлаас багш сурагчдын тэмцээн уралдааны замын зардалд 1,852.0 мянган төгрөг, цахим хэрэглээний зардлаас бичиг хэрэг, номын санч, эмч нягтлан бодогч, нярав нарт 750.0 мянган

төгрөгийн дата олгосон нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах;” заалт, БШУС-ын 2019 оны А/170 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах заавар”-тай нийцэхгүй, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Төсвийг батлагдсан зориулалт, арга хэмжээний дагуу, холбогдох хууль, журам, зааварт нийцүүлэн зарцуулж байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Элэгдлээрээ өртгөө нөхсөн ашиглагдаж байгаа үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг дахин сунгаж элэгдэл тооцоогүй	1	0					1	0				
Танхимаас гадуур сургалтын зардал, цахим хэрэглээний зардлын ангилал зөрчсөн	1	2,602.0					1	2,602.0				
Боловсрол, шинжлэх ухааны газрын арга зүйн хэлтсийн дарга Я.Дүүрэнбилэгтэй гэрээ байгуулан, сургалт хийлгэж төсвөөс 2,500.0 төгрөгийн төлбөр төлсөн	1	2,500.0	1	2,500.0								
<b>Дүн</b>		<b>5102.0</b>		<b>2,500.0</b>			<b>2</b>	<b>2,602.0</b>				

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2024 оны 02 сарын 26 өдөр

№ 39/АЭЭТ0439/ХӨА-2024/  
195/ХӨА-С/М.А-МШЗ

Мөрөн сум

### Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн Чандмань-өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. **Үүнд:**

Багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээний батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргахдаа мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, багш, ажилтны мэргэжлийн хөгжлийг хангах, зөвлөн туслах чиг үүрэгтэй аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын заах аргын нэгдлийн хэлтсийн дарга Я. Дүүрэнбилэгтэй гэрээ байгуулан, сургалт хийлгэж 2,500,000/ хоёр сая таван зуун мянга / төгрөгийн төлбөр төлсөн байна.

Энэ нь Боловсролын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.5-д "Аймаг, нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтэс харьяа нутаг дэвсгэртээ дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: өмчийн хэлбэр үл харгалзан бүх түвшний боловсролын сургалтын байгууллагад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, багш, ажилтны мэргэжлийн хөгжлийг хангах, зөвлөн туслах", Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаал "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах чиг үүрэгтэй албан хаагчид гэрээгээр төлсөн төлбөр 2,500,000/ хоёр сая таван зуун мянга / төгрөгийг Боловсрол, шинжлэх ухааны газрын Заах аргын нэгдлийн хэлтсийн дарга Я. Дүүрэнбилэгээс гаргуулж Хөвсгөл аймгийн Төрийн сан дахь 100170000955/Хө.Бусад нэр заагдаагүй орлого/ тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар<sup>1</sup>т нотлох баримтын хамт ирүүлэхийг Чандмань-өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал А.Отгонбаяр, нягтлан бодогч Д.Байгальмаа нарт хариуцуулав.

### ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
"ИХЭР МӨРӨН АУДИТ" ХХК  
ЗАХИРАЛ

А.ЭРДЭНЭБААТАР

Б.МЯДАГМАА

<sup>1</sup> Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байр, А корпус, 3 давхар, 303 тоот